



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ
УЛААН ТУГИЙН ОДОНТ
**АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/14.

Улаанбаатар хот

САР ШИНИЙН БАЯРЫН ӨДРҮҮДЭД
ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮР
ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, мөн хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалт, ЭМЯ-ны 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 5/453 тоот албан зөвлөмж, чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сар шинийн баярын өдрүүдээр тус төвийн эмнэлгийн тусламжийн тасралтгүй байдлыг ханган ажиллах албан хаагчдын хуваарийг нэгдүгээр хавсралтаар, онцгой байдал үүссэн тохиолдолд холбоо барих албан тушаалтны нэрс, утасны дугаар зэргийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Баярын үеэр яаралтай тусламжийн эм, тариа, ороох боох материал, ариутгал, халдваргүйжүүлэх бодис, хордлого тайлах шингэнийг хүрэлцэхүйц хэмжээгээр ханган нийлүүлж Хүлээн авах тасагт байршуулахыг ЭЭЯТТасгийн эрхлэгч Д.Чанцалдулам, Эм зүйн албаны дарга Э.Мөнхгэрэл нарт үүрэг болгосугай.

3. Баярын үеэр болзошгүй нийтийг хамарсан хоолны хордлого, гэмтэл осол өртсөн хүмүүст үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний шуурхай бэлэн байдлыг ханган ажиллах, ноцтой алдаа, зөрчил гарсан үед ЭМЯ-ны хариуцлагатай жижүүрт шууд мэдээллэхийг /11-323002/ жижүүрийн ахлах эмч нарт үүрэг болгосугай.

4. Баярын өдрүүдэд тус төвийн Удирдлагын багийн томилгоот гишүүд, Поликлиник болон Клиникийн тасгийн эрхлэгч болон энэхүү тушаалын хавсралтад заагдсан албан хаагч **утсаа нээлтэй** байлгаж, дуудсан тохиолдолд шуурхай ирж ажиллахыг үүрэг болгосугай.

5. Баярын үеэр ажиллаж байгаа хариуцлагатай эмч, эмнэлгийн мэргэжилтэн болон үйлчилгээний албан хаагчид сонор сэрэмжтэй байж, анхаарал сулрах, ажлын

хариуцлага алдах, ажлын байрыг дур мэдэн орхих, ажлын байранд архи, согтууруулах төрлийн ундаа хэрэглэх зэрэг асуудал гаргахгүй байхыг онцгойлон анхааруулсугай.

6. Хариуцлагатай жижүүрийн ажиллаж байгаа байдал, тэдгээрт хяналт тавьж ажиллахыг тус төвийн Эмнэл зүй эрхэлсэн дэд захирал /Б.Батцэцэг/, Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал /Т.Баярмаа/ нарт даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ЦУРАНЧИМЭГ